"АПЛИТИКАЛ АУДИТ" ХХК

6570674, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 5-р хороо,
Бүрэн төв, 501 тоот
Утас: 7016-1628, 9400-1628
И-мэйл: audit.manager@uplytical-audit.mn

2023.02.07 № 61/23
танай _____-ны № _____т

ШАТТЛЕ ББСБ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ М.БИЛГҮҮНСАЙХАН
ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид Шаттле ББСБ ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Шаттле ББСБ ХХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс батлсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

УЛААНБААТАР ХОТ
АПЛИТИКАЛ АУДИТ ХХК

Г.Бадар-Уугай

Захирал
Аплитикал-Аудит ХХК

ШАТТЛЕ ББСБ ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Тод-руулга	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	223,588.3	448,479.0
Зээл (Цэвэр)	4	3,570,129.8	3,260,588.0
Бусад авлага	5	350,543.9	499,925.1
Бусад хөрөнгө		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		**4,144,262.1**	**4,208,992.2**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	6	4,975.0	6,539.1
Биет бус хөрөнгө	7	2,502.5	2,047.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**7,477.5**	**8,586.6**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**4,151,739.6**	**4,217,578.8**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
БУСАД ЭХ ҮҮСВЭР		-	-
Богино хугацаат өр төлбөр	8	18,534.3	20,660.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**18,534.3**	**20,660.3**
Урт хугацаат өр төлбөр		-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**18,534.3**	**20,660.3**
Өр төлбөрийн дүн			
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
ЭЗДИЙН ӨМЧ			
ХУВЬЦААТ КАПИТАЛ		3,301,000.0	3,301,000.0
Дүрмийн сан		832,205.3	895,918.5
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		**4,133,205.3**	**4,196,918.5**
Эздийн өмчийн дүн		**4,151,739.6**	**4,217,578.8**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН			

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

АПЛИТИКАЛ АУДИТ ХХК

ШАТТЛЕ ББСБ ХХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод-руулга	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
Хүүгийн орлого	9	174,183.4	297,393.4
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		**174,183.4**	**297,393.4**
Хүүгийн бус орлого		-	-
Хүүгийн бус зардал	10	(160,986.5)	(123,956.7)
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН		**(160,986.5)**	**(123,956.7)**
Зээлийн эрсдэлийн зардал		-	(113,761.8)
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)		**13,196.9**	**59,674.9**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	11	43,799.4	11,117.5
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		**56,996.3**	**70,792.5**
Орлогын татварын зардал		(5,699.6)	(7,079.2)
Цэвэр ашиг (алдагдал)		**51,296.7**	**63,713.2**

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

АПЛИТИКАЛ АУДИТ ХХК 4

ШАТТЛЕ ББСБ ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	**Өмч**	**Хуримтлаг-дсан ашиг**	**Нийт дүн**
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,301,000.0	780,908.6	**4,081,908.6**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	3,301,000.0	780,908.6	**4,081,908.6**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		51,296.7	**51,296.7**
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Өмчид гарсан өөрчлөлт	-		-
Хуваарилсан ногдол ашиг		-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**3,301,000.0**	**832,205.3**	**4,133,205.3**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	3,301,000.0	832,205.3	**4,133,205.3**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		63,713.2	**63,713.2**
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Өмчид гарсан өөрчлөлт			
Хуваарилсан ногдол ашиг		-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**3,301,000.0**	**895,918.5**	**4,196,918.5**

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

АПЛИТИКАЛ АУДИТ ХХК

ШАТТЛЕ ББСБ ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

Ангилал	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**157,633.4**	**350,909.8**
Зээлийн хүүгийн орлого	157,633.4	350,909.8
Мөнгөн зарлагын дүн (-)	**(183,671.5)**	**(130,019.1)**
Үндсэн ба нэмэгдэл цалин	(57,727.7)	(52,351.1)
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	(15,451.1)	(18,587.0)
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	(5,328.9)	(5,996.9)
Татвар, даатгалын төлсөн мөнгө	(5,599.1)	(12,898.0)
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	(1,500.0)	(1,500.0)
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	(2,700.0)	(2,700.0)
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	(76,321.9)	
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	(19,042.8)	(35,986.0)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(26,038.1)**	**220,890.7**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**3,560.9**	**4,000.0**
Бусад	3,560.9	4,000.0
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**3,560.9**	**4,000.0**
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(22,477.2)	224,890.7
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	246,065.5	223,588.3
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	223,588.3	448,479.0

Энэхүү санхүүгийн тайлангуудыг тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

АПЛИТИКАЛ АУДИТ ХХК